

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Лувсандоржийн ЭНХМӨНХ

Сургалтын хэрэглэгдэхүүн бол биеийн тамирын хичээлд суралцагчдыг идэвхжүүлэх арга мөн

Мэргэжил: Биеийн тамирын багш

Говьсүмбэр аймаг 2018 он

АГУУЛГА

1. Түлхүүр үг
2. Оршил
3. Судалгааны зорилго
4. Судалгааны зорилт
5. Судалгааны объект
6. Судалгааны арга зүй
7. Дүгнэлт
8. Ном зүй

Түгжлүүр үг

Биеийн тамирын хичээл, сонирхол, идэвхжүүлэх арга, хэрэглүүр, сургалтын хэрэгсэлдэхүүн

Огнол

Сэдвийг сонгосон үндэслэл:

Сурган хүмүүжүүлэх ном зохиолд сургалт гэдэг ойлголтыг батшийн хүмүүжүүлэх болон суралцагчийн сурах үйл ажиллагааны нэгдэл юм гэж тайлбарласан байдаг. Монголын хүүүхэд бүрийг эрүүл чийрэг иргэн болгон төлөвшүүлэхэд биеийн тамирын сургалт маш их үүрэгтэй.

Зах зээлийн нийгэмд хүний эрүүл мэнд бол тухайн хүний гол баялаг үнэт зүйл гэдгийг суралцагч бүрт ойлгуулж, өөрийгөө чийрэгжүүлэн хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал, хэвшлийг бүрдүүлэн, тусалж дэмжих нь биеийн тамирын сургалтын гол үүрэг байх ёстой.

Бүх шатны боловсролын байгууллага нь сургалтын төлөвлөгөөндөө биеийн тамирын хичээлийг заавал оруулахыг хуулиар тогтоосон байна. Энэ нь тус сургалтыг суралцагчдын идэвхийг өрнүүлэх, бүтээлч аргүүдыг илүү ашиглахыг шаардаж байгаагаас үзэхэд, биеийн тамирын сургалтын арга зүйт сайжруулах нь өнөөдрийн тулгамдсан асуудал болж байна.

Биеийн тамирын сургалтын чанар үр дүн нь:

- ✓ Биеийн тамирын заал, талбай орчин
- ✓ Батшийн мэдлэг, үр чадвар
- ✓ Суралцагчийн идэвх, оролцоо
- ✓ Сургалтын хэрэгсэлдэхүүний онцлог зэргээс нэлээд хэмжээгээр шалтгаалдаг.

Биеийн тамирын сургалт нь хүүхдийн нас, хүйс, бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн түвшинд тохирсон сургалтын хэрэгсэлдэхүүнийг шаардана. Ажиллагт, туршилтаас сургалтын хэрэгсэлдэхүүн, сургалтын арга зүйт сайжруулах, боловсронгуй болгох батш нар хамтран ажиллаж, байнга эрэл хайгуул хийх, хөгжих, тасралтгүй суралцах нь чухал байна.

Биеийн тамирын хичээлд батш суралцагч хоёулаа идэвхтэй оролцох нь зорилгоо амжилттай хэрэгжүүлнэ гэсэн үг.

Суралцагчийн сурах үйлийг идэвхжүүлэх аргыг “Идэвхтэй сургалтын арга” гэнэ. Иймээс төрөл бүрийн хэрэгсэлдэхүүнийг ашиглан суралцагчдын

биеийн тамирын хичээлд идэвхжүүлэх боломжийг туршиж, үр дүн нь тохирох аргыг мэдэх зорилгоор энэ сэдвийг сонгож авлаа.

Судалгааны ажлын зорилго:

Сургалтын хэрэглэгдэхүүн бол биеийн тамирын хичээлд суралцагчдыг идэвхжүүлэх арга мөн гэдгийг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын зорилт:

1. Биеийн тамирын хичээлд суралцагчдын идэвхийг өрнүүлэхэд сургалтын хэрэглэгдэхүүн чухал гэдгийг судлах
2. Биеийн тамирын хичээлд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох

Судалгааны ажлын объект:

Судалгаанд: Биеийн тамирын хичээл дээр ХММО – 1а, б ангиудад туршилт хийсэн.

ЕБС, Мэргэжлийн боловсролд 10 дахь жилдээ ажиллаж байгаа биеийн тамир, эрүүл мэндийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд сууж байгаа 34 биеийн тамирын багшийг хамруулсан болно.

Судалгааны ажлын арга зүй:

Ажиглалт, туршилт, асуулга анкет, харьцуулан нэгтгэн дүгнэх, аргуудыг хэрэглэсэн.

1. БИЕИЙН ТАМИРЫН ХИЧЭЭЛ ДЭЭР СУРАЛЦАГЧДЫН ИДЭВХЖСЭН БАЙДАЛ

№	Идэвхийг өрнүүлэх шалгуур	Туршилтын хичээл	Хяналтын хичээл
1	Суралцагч өөрийгөө дайчилж бөмбөгийг залж, хурдтай гүйхийг хичээж буй байдал	- Тэмдэгтийг сүлжиж, бөмбөгийг маш хурдан залж гүйсэн - Тодорхой зорилго тавьж өөрийгөө дайчилж гүйх	- Дараалалаа хүлээж идэвхгүй зогсох - Хурд багатай гүйх - Өөрийн ээлжээ хүлээхдээ хоорондоо ярих
2	Бие биенийгээ, сүлжиж, уралдаж өрсөлдөх байдал	- Хашгирах - Нэгнийгээ нэрээр нь дуудах - Бие биенээ дэмжих	- Бусдыгаа шоолох - Нэг нь гүйж байхад нөгөө нь алхаж байрандаа ирэх - Цуваанаасаа хоцрох, тасрах
3	Сэтгэлийн хөдөлгөөнөө үг ба биеэрээ илэрхийлэх байдал	- Дороо дэвхцэх - Алга таших	- Нэгнийгээ холдооч би гүйе - Уурлах

Хүснэгт 1

Биеийн тамирын хичээл дээр туршиж үзэхэд хэрэглэгдэхүүн нь:

Суралцагчдын идэвхийг өрнүүлж, сурах сэдлийг өдөөж, хүүхэд бүрийн дотоод нөөц боломжийг дайчлахад хүчтэй дэмжлэг болж байгааг харуулж байна.

Биеийн тамирын хичээлд хэрэглэгдэхүүний туршилтын хичээл



Хяналтын хичээл



Хяналтын хичээл



Сонгон дугуйлан хяналтын хичээл болж байна. Хэрэв бүх суралцагч, эсвэл 2-3 суралцагч дундаа нэг бөмбөгтэй байсан бол суралцагчдын идэвх илүү болж, давтах, сурахад өөрийн болгоход дөхөм байх байсан.



2. БИЕИЙН ТАМИРЫН ХИЧЭЭЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Судалгаанд ЕБС, Мэргэжлийн боловсролд 10 дахь жилдээ ажиллаж байгаа биеийн тамир, эрүүл мэндийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд сууж байгаа 34 биеийн тамирын багшийг хамруулсан болно.

Судалгаанд оролцсон багш нарын насны ангилалаар авч үзвэл:



График 1

Дээрх графикаас харахад 33 хүртлэх насны 12 багш, 34-38 насны 14 багш, 40 –с дээш насны 8 багш байгаа нь сургалтанд 40 –с доош насны залуу багш нар илүү байгааг харуулж байна.

Асуулт 1: Та биеийн тамирын хичээл заахад тулгамдаж буй асуудал юу гэж үзэж байна вэ?



График 2

Судалгаанд оролцогчдын 14 буюу 41% сургалтын хэрэглэгдэхүүн, 9 буюу 26% сурах бичиг, 8 буюу 24% нь сургалтын орчин, заал, талбай, 3 буюу 9% нь бусад гэсэн нь нэн түрүүнд сургалтын хэрэглэгдэхүүн чухал байна.

Асуулт 2: Та хичээлээ ямар аргаар зохион байгуулан явуулдаг вэ?



График 3

Судалгаанд оролцогчдын 10 хүн буюу 29% нь тэмцээний арга, 8 хүн буюу 23% нь тоглоомын арга, 6 хүн буюу 18% нь хэсэг буюу багт хуваах арга, 5 хүн буюу 15% нь тойргийн арга, 3 хүн буюу 9% нь нийтээр заах арга, 2 хүн буюу 6% нь ганцаарчилсан арга гэж хариулсан нь биеийн тамирын багш нар тэмцээний аргыг ихэвчлэн хэрэглэдэг байна.

Асуулт 3: Ахлах ангийн суралцагчдад ямар дасгалыг түлхүү өгөх нь тохиромжтой гэж үздэг вэ?



График 4

Судалгаанд оролцогчдын 12 буюу 41% олон төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн ашигласан дасгал, 10 буюу 33% мэдээлэл технологи ашигласан дасгал, 8 буюу 21% нь нэгэн хэвийн ачаалалтай дасгал, 4 буюу 5% нь ачаалалыг ихэсгэж хүндрүүлсэн дасгал гэсэн нь нэн түрүүнд сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах нь тохиромжтой гэж үзсэн байна.

Асуулт 4: Та өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлээ дээшлүүлэхэд анхаарч ажилладаг уу?




График 5

Судалгаанд оролцогчдын 14 хүн буюу 41% нь тийм, 11 хүн буюу 32% нь заримдаа, 9 хүн буюу 27% нь үгүй гэж хариулсан нь багш өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлээ дээшлүүлэхэд анхаарч ажилладаг нь харагдаж байна.

Судалгааны үр дүнгээс харахад Биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүн, тэмцээний аргыг түлхүү хэрэглэх нь хүүхдийг идэвхжүүлэх аргын нэг бөгөөд энэ тал дээр цаашид анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.



ДҮГНЭЛТ

1. Туршилтад ашиглагдсан хэрэглэгдэхүүнүүд хүүхдийн сурах сэдлийг өдөөж, хүүхэд бүрийн дотоод нөөц боломжийг дайчлахад дэмжлэг болж байна.
2. Суралцагчид бөмбөгөөр залалт хийн, тэмдэгт сүлжин гүйхдээ амжилтаа ахиулах, багаа дэмжих, хоцрохгүй байхыг хичээж байгаа нь тэдний хөдөлгөөний чадварыг сайжруулж, хурд, хүчийг хөгжүүлэхэд нөлөөлнө.
3. Өнөөгийн хүүхдийн сонирхол хэрэгцээ нь технологийн хөгжилтэй уялдан өөрчлөгдөж байгааг тооцож, биеийн тамирын сургалтанд ашиглах дасгал хэрэглэгдэхүүн ч өөрчлөгдөх шаардлагатай болж байна.
4. Биеийн тамирын сургалтыг зохион байгуулахдаа олон төрлийн сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж ашиглах нь суралцагчдыг идэвхжүүлэх арга мөн. Үүнд:
 - ✓ Дасгалыг хийх сонирхолыг дээшлүүлнэ
 - ✓ Бүтээлч хандлага бий болно
 - ✓ Сэтгэн бодох чадварыг сайжруулна
 - ✓ Хөдөлгөөний эвсэлийг хөгжүүлнэ
 - ✓ Тэмцээн, уралдааны амжилт ахина
 - ✓ Багш, суралцагчийн хамтын бүтээлч үйл ажиллагаа, арга барил өөрчлөгдөнө гэж дүгнэж байна.

Дасгал
Туршилт

... Хүн бүрийн амьдардаг орчин, иддэг хоол, өмсдөг хувцас өөр байдаг шиг сурах, сургах арга барил ч өөр...

НОМ ЗҮЙ

Ном, нэг сэдэвт бүтээл, судалгааны материал, илтгэл

1. Ж. Амаржаргал /2004/ “Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй”
Улаанбаатар Сейжи принт
2. Л. Уртнасан /1998/ “Тоглоомын аргаар хүүхдийн бие бялдрыг
хөгжүүлэх” Улаанбаатар Старлайн ХХК
3. Ц. Тамир /2014/ “Багшийн ном Биеийн тамир –IV” Улаанбаатар
Адмон принт ХХК
4. Г. Цэрэндорж /1997/ “Хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх ажлын
агуулга арга зүй, зохион байгуулалт” Улаанбаатар
5. Д. Мэндбаяр, З. Самданжамц /2018/ “Мэргэжил дээшлүүлэх үндсэн
сургалтын гарын авлага” Улаанбаатар

Веб сайтууд

1. www.inet.mn
2. www.nets.mn
3. www.edub.edu.mn

ӨӨРИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Овог нэр: Лувсандорж овогтой Энхмөнх

Сургууль: УУЖС Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

Мэргэжил: Биеийн тамирын багш

Ажилласан жил: 21

Боловсролын зэрэг: Магистр

Мэргэжлын зэрэг: Тэргүүлэх

Спортын зэрэг: Волейболын спортын мастер, сагсан бөмбөгийн 1-р зэрэг,
ширээний теннисний 2-р зэрэгтэй.

